**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# Нийцлийн аудитын тайлан

Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны хөрөнгийн зарцуулалт







**ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудад хяналтын хороод чиг үүргээ хангалттай биелүүлээгүй, ОНХС-гийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлдэг зөрчил давтагдан гарсаар байна.**

**2019 он**

## АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа

Ахлах аудитор Ц.Батсайхан

Аудитор М.Ундармаа

2019 оны 03-04 дүгээр сар

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7054-3156 дугаарын утас,7054-3179 дугаарын факсаар харилцана уу.

Байгууллагын хаяг:

ГСА Сүмбэр сум 3-р баг, Нутгийн удирдлагын ордон 2-р давхар б корпус 208 тоот

Товчилсон үгийн тайлбар ..................................4

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй............................................................................5

**Нэг. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын чанар, үр дүн хангалтгүй байна.**

1.1 ОНХНС-гаас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгосон байна.

1.2 **Аймгийн ОНХС-гийн хөрөнгийн эх үүсвэрийг** хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна.

1.2.1 **Аймаг, сумдын ОНХС-гийн эх үүсвэрийг төлөвлөхдөө холбогдох журамд заасан нэр, төрлөөр нь тооцож төлөвлөсөн байна.**

1.2.2 Аймаг, сумдын ОНХС-гийн эх үүсвэрийг хуульд заасан боломжит эх үүсвэр тус бүрээр бүрдүүлсэн байна.

1.2.3 Аймгийн ОНХС-гаас сумдын ОНХС-д орлогын шилжүүлгийг хуваарилахдаа холбогдох хуулийн заалтыг баримтласан байна.

**Хоёр. ОНХС-гийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг баталж, хэрэгжүүлдэг зөрчил давтагдан гарсаар байна.**

2.1 ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох хууль тогтоомж, зааврыг баримтлаагүй, ОНХС-гийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлдэг зөрчил давтагдан гарсаар байна.

2.2.1 Зарим үнэлгээний хороо, ажлын хэсэг холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүйгээс жил бүр сонгон шалгаруулалттай холбоотой гомдол, санал гарч байна.

2.2.2. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн зарим ажлууд чанарын шаардлага хангаагүй, үр дүн, ашиглалт муутай байна.

2.2.3 ОНХС-гийн санхүүжилтээр бий болсон

| | |
|---|---|
| | хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй, аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна.<br><br>**Гурав. ОНХС-гийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт хийгдээгүй байна.** |
| | 3.1.1 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллаагүй байна. |
| | 3.1.1 Аймаг, сумдын ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо, иргэд, Иргэний нийгмийн байгууллагуудаас тавих хяналт хангалтгүй байна. |
| | 3.1.2 Аймаг, сумын захиргааны байгууллага ОНХС-гийн хэрэгжилт, үр дүнд хийх хяналт, шинжилгээ үнэлгээг хийгээгүй байна. |
| | 3.2.1 Аймаг, сумд ОНХС-гийн хэрэгжилтийн тайланг хүргүүлж ажилласан байна.<br><br>3.2.2 Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагын хэрэгжилт 69.4 хувьтай байна. |
| | |

# Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

## 1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн Төсвийн байнгын хорооны 2018 оны “Аудитын сэдэв батлах тухай” 01 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторт 2019 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

## 2. Аудитын зорилго, зорилт

Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэх, үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд аудит хийж, аудитаар илэрсэн зөрчлийг арилгах, цаашид сайжруулах санал зөвлөмж боловсруулан дүнг ҮАГ болон АИТХ, холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

## 3. Аудитын хамрах хүрээ

Аудитад аймаг, сумдын ИТХ, Засаг дарга, ИНХ, багийн Засаг дарга, СТСХ-ийг хамруулж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2018 оны орлого бүрдүүлэлт, төсөв төлөвлөгөө, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал зэргийг авч үзлээ.

## 4. Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөр, АДБОУС 100-400, 4000, 4100, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан аудитын арга зүйн дагуу орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, тогтоол, түүнийг дагалдан гаргасан эрх зүйн актуудын хүрээнд хэрэгжүүлэгч байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, санал асуулга, лавлагаа, тодруулга авч бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх, үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн зорилтод арга хэмжээнээс түүвэрлэн горим сорил хэрэгжүүллээ.

Мөн аудитын хүрээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн талаарх иргэдийн мэдээлэл, оролцоог үнэлэх зорилгоор аймаг болон 3 сумын нийт 100. иргэнээс санал асуулга авлаа.

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

## 5. Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, ахлах аудитор Ц.Батсайхан, аудитор М.Ундармаа нар хийж гүйцэтгэлээ.

## 6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, түүнд өгсөн тайлбар, хавсралт гэсэн бүтцээр үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

## 7. Үндсэн мэдээлэл

ОНХНС болон улсын төсвөөс аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг тооцохдоо Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал", Сангийн сайдын 2016 оны 17 дугаар тушаалаар батлагдсан "Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлэг тооцох аргачлал"-ыг тус тус мөрдөж байна.

Мөн орон нутгийн удирдлага улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, нутгийн захиргаа, иргэд, олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам", 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар", 2018 оны 288 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ыг тус тус баримтлан хэрэгжүүлж байна.

Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хуулиар Говьсүмбэр аймагт ОНХНС болон улсын төсвөөс ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 644.6 сая төгрөгөөр баталсан бөгөөд тайлант онд уг хуульд нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

2018 онд аймгийн хэмжээнд ОНХС-нд нийт 2,599.5 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж ажилласан байна. Үүнд: Өмнөх оны үлдэгдлээс 675.8 сая, ОНХНС-гаас 644.6 сая, 2017 оны давсан орлого, хэмнэгдсэн зардлаас 649.7 сая, орон нутгийн төсвийн орлогоос 628.9 сая, өмнөх оны хөтөлбөрийн хэмнэлтээс 0.5 сая төгрөг тус тус байна.

**Аймаг, сумдын ОНХС-гийн эх үүсвэрийг хүснэгтээр харуулбал:**

/сая төгрөгөөр/

| Сангийн нэр | Өмнөх оны үлдэгдлээс | ОНХНС-гаас | Орон нутгийн төсвийн орлогоос | Өмнөх оны хөтөлбөрийн хэмнэлт | 2017 оны давсан орлого, хэмнэгдсэн зардлаас | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| Аймгийн ОНХС | 587.6 | 297.3 | 476.1 | 0.5 | 649.7 | 2,011.2 |
| Сүмбэр ОНХС | 53.1 | 206.7 | 75.8 | | | 335.5 |
| Шивээговь ОНХС | 10.8 | 106.5 | 55.9 | | | 173.1 |
| Баянтал ОНХС | 24.4 | 34.1 | 21.2 | | | 79.7 |
| Нийт дүн | 675.8 | 644.6 | 628.9 | 0.5 | 649.7 | 2,599.5 |

Хүснэгтээс харахад: Эх үүсвэрийн 77.4% буюу 2,011.2 сая төгрөгийг АОНХС, 12.9% буюу 335.5 сая төгрөгийг Сүмбэр сумын ОНХС, 6.7 % буюу 173.1 сая төгрөгийг Шивээговь сумын ОНХС, 3.1% буюу 79.7 сая төгрөгийг Баянтал сумын ОНХС тус тус эзэлж байна.

2018 онд анх Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд нийт 1,890.4 сая төгрөгийн төсөв батлагдаж, аймгийн ИТХ-ын 2018.05.28-ны өдрийн хуралдааны 03 дугаар тогтоолоор аймгийн ОНХС, орон нутгийн хөрөнгө оруулалтыг 2017 оны орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээс санхүүжүүлэхээр зардлыг жагсаалтаар баталж, 688.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан уу?

# Бүлэг 1

**ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын чанар, үр дүн хангалтгүй байна.**

## 1.1 ОНХНС-гаас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгосон байна.

Тус аймагт 2018 онд ОНХНС-гаас дотоодын НӨАТ-аас 131.2 сая, газрын тосны НАТ-аас 61.8 сая, АМНАТ-өөс 250.5 сая, Тогтвортой амьжиргаа-3 төслөөс дэмжлэг Баянтал суманд 19.5 сая, Сүмбэр суманд 69.6 сая, Шивээговь суманд 51.3 сая, урамшуулал Сүмбэр суманд 43.9 сая, Шивээговь суманд 16.8 сая, нийт 644.6 сая төгрөгийн орлогын шилжүүлэг олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр шилжүүлгийг бүрэн олгосон байна.

## 1.2 Аймгийн ОНХС-гийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна.

### 1.2.1 Аймаг, сумдын ОНХС-гийн эх үүсвэрийг төлөвлөхдөө холбогдох журамд заасан нэр, төрлөөр нь тооцож төлөвлөсөн байна.

2018 онд анх Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд нийт 1,890.4 сая төгрөгийн төсөв батлагдаж, аймгийн ИТХ-ын 2018.05.28-ны өдрийн хуралдааны 03 дугаар тогтоолоор аймгийн ОНХС, орон нутгийн хөрөнгө оруулалтыг 2017 оны орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээс санхүүжүүлэхээр зардлыг жагсаалтаар баталж, 688.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

**Аймаг, сумдын 2018 оны орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:**

/сая төгрөгөөр/

| ОНХС-гийн орлогын нэр | Орлогын | | Зөрүү |
|---|---|---|---|
| | Төлөвлөлт | Гүйцэтгэл | |

| | | | |
|---|---|---|---|
| **ОНХНС-гаас олгох шилжүүлгийн орлого** | 644.6 | 644.6 | 0.0 |
| **ОН-ийн төсвийн орлогоос санхүүжих** | 628.9 | 628.9 | 0.0 |
| **ОНХС-ийн өөрийн орлого** | 0.0 | 0.5 | 0.5 |
| **2017 оны дансны үлдэгдэл** | 556.0 | 675.8 | 119.8 |
| **2017 оны давсан орлого, хэмнэгдсэн зардлаас** | 60.9 | 649.7 | 588.8 |
| **Нийт дүн** | **1,890.4** | **2,599.5** | **709.1** |

Хүснэгтээс харахад: Төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүү 709.1 сая төгрөг нь аймгийн ОНХС нь 2017 оны орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээс санхүүжүүлэхээр зардлыг 688.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, өмнөх оны хөтөлбөр арга хэмнэлтээс буцаан тушаагдсан 0.5 сая, тайлант онд төсөвт тодотгол хийгээгүйгээс Сүмбэр сумын ОНХС нь 2017 оны дансны эхний үлдэгдлийг 20.4 сая төгрөгөөр дутуу тодотгосон зэргээс зөрүү үүссэн байна

### 1.2.2 Аймаг, сумдын ОНХС-гийн эх үүсвэрийг хуульд заасан боломжит эх үүсвэр тус бүрээр бүрдүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-т заасны дагуу аймаг, сумдын ОНХС-гийн орлогын эх үүсвэрийн нийт 2,599.5 сая төгрөгийг дараах 5 нэр, төрлийн орлогоос бүрдүүлсэн байна. Үүнд:

1. ОНХНС-гаас олгох шилжүүлгийн орлого
2. Орон нутгийн татварын орлого
3. ОНХС-гийн өөрийн орлого
4. 2017 оны дансны үлдэгдэл
5. 2017 оны давсан орлого, хэмнэгдсэн зардлаас тус тус бүрдүүлжээ.

Харин Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.5-д заасан дотоод гадаадын хандив, тусламжийн эх үүсвэрийг төлөвлөөгүй байна.

Аймаг, сумдын ОНХС-гийн орлогын эх үүсвэрийг нэр, төрлөөр нь хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

| ОНХС-гийн орлогын нэр | Аймгийн ОНХС | Сүмбэр сумын ОНХС | Шивээговь сумын ОНХС | Баянтал сумын ОНХС | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **ОНХНС-гаас олгох шилжүүлгийн орлого** | 297.3 | 206.7 | 106.5 | 34.1 | 644.6 |
| **ОН-ийн төсвийн орлогоос** | 476.1 | 75.7 | 55.9 | 21.2 | 628.9 |
| **ОНХС-ийн өөрийн орлого** | 0.5 | | | | 0.5 |
| **2017 оны дансны үлдэгдэл** | 587.6 | 53.1 | 10.8 | 24.3 | 675.8 |
| **2017 оны давсан орлого, хэмнэгдсэн зардлаас** | 649.7 | | | | 649.7 |
| **Нийт дүн** | **2,011.2** | **335.5** | **173.2** | **79.6** | **2,599.5** |

Хүснэгтээс харахад: Нийт эх үүсвэрийн 24.8% буюу 644.6 сая төгрөгийг ОНХНС-гийн шилжүүлгийн орлогоос, 24.2% буюу 628.9 сая төгрөгийг ОН-ийн

төсвийн орлогоос, 26% буюу 675.8 сая төгрөгийг 2017 оны дансны үлдэгдлээс, 25% буюу 649.7 сая төгрөгийг 2017 оны давсан орлого, хэмнэгдсэн зардлаас тус тус бүрдүүлсэн байна.

### 1.2.3 Аймгийн ОНХС-гаас сумдын ОНХС-д орлогын шилжүүлгийг хуваарилахдаа холбогдох хуулийн заалтыг баримтласан байна.

2018 онд ОНХНС-гаас олгогдсон 644.6 сая төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих суурь зарлагыг хасч тооцон, үлдэгдлийг аймаг, сумдад итгэлцүүрийн дагуу хуваарилсан бөгөөд сумдын Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг тооцохдоо Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 3 дугаар зүйлийн 3.2-т заасан орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо, хүн амын нягтрал алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ зэрэг нөлөөлөх байдлыг харгалзан хуваарилсан байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих суурь зарлага болон ОУБ-ын урамшуулал болох нийт 294.2 сая төгрөгийг хасч тооцон үлдэгдэл 350.4 сая төгрөгийн санхүүжилтийн 30% буюу 105.1 сая төгрөгийг сумдын ОНХС-д, 70% буюу 245.2 сая төгрөгийг аймгийн ОНХС-д тус тус хуваарилсан байна. Тухайлбал:

1. Мал эмнэлгийн үйлчилгээний суурь зардалд 15.1 сая,
2. “Тохижилт-Сүмбэр” ОНӨААТҮГ-ын санхүүжилтэд 41.0 сая,
3. Ус хангамжийн татаас 36.9 сая,
4. Олон улсын байгууллага буюу “Тогтвортой амжиргаа-III” төслөөс олгогдсон 201.2 сая төгрөгийн урамшуулал нь сумдад нэр заагдаж төлөвлөгдсөн тул аймаг, сумдад итгэлцүүрээр хуваарилах санхүүжилтээс тус тус хасч тооцсон байна.

ОНХНС-гаас 2018 онд аймаг, сумдад олгосон орлогын шилжүүлгийг диаграммаар харуулбал:



Диаграммаас харахад: Аймгийн ОНХС-д 245.3 сая, Сүмбэр сумын ОНХС-д 52.2 сая, Шивээговь сумын ОНХС-д 38.4 сая, Баянтал сумын ОНХС-д 14.6 сая төгрөгийг тус тус хуваарилсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан уу?

# Бүлэг 2

**ОНХС-гийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг баталж, хэрэгжүүлдэг зөрчил давтагдан гарсаар байна.**

**2.1 ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох хууль тогтоомж, заавлыг баримтлаагүй, ОНХС-гийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлдэг зөрчил давтагдан гарсаар байна.**

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12 дугаар зүйлд тухайн шатны Засаг дарга ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс санал авч урьдчилсан жагсаалт бэлтгэн олон нийтээр хэлэлцүүлж, нийтийн эрх ашигт нийцсэн нэгдсэн жагсаалтыг ИТХ-д өргөн мэдүүлэхээр заасан.

Мөн дээрх журмын 6.3.4, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 2.2, 4.1 дэх заалтуудад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь улсын хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөр, УИХ, Засгийн газар болон тухайн орон нутгаас хөгжлийн талаар баримталж байгаа бодлого стратеги, орон нутгийн дунд хугацааны төлөвлөлттэй уялдсан байхаар тусгасан байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрээр 2018 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг аймаг, сумыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, Засаг даргын хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, тухайн орон нутгийн эдийн засаг, нийгмийн зорилт зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөсөн байна.

Аймгийн ХОХБТХ болон Баянтал, Шивээговь сумдын ОНХС хариуцсан мэргэжилтэн нь аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг төлөвлөхдөө хууль журмын дагуу аймаг, сумдын иргэд, орон нутгийн төсвийн болон ОНӨААТҮГ-аас санал авч, урьдчилсан саналын жагсаалтыг боловсруулж иргэдэд танилцуулж, багийн ИНХ-аар хэлэлцүүлэн саналыг эрэмбэлэн ажилласан ба эцэслэсэн жагсаалтыг аймаг, сумдын ИТХ-аар батлуулсан байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг ИНХ-аар хэлэлцүүлэхдээ хурал оролцогчдын ирцийг 3 сум гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан боловч аймаг баталгаажуулаагүй байна.

Харин тухайн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлснээс бий болох үр өгөөжийг хэн хүртэх, хэдэн хүн ашиг хүртэх, иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлөх талаар тооцсон тооцоо судалгаа байхгүй байна.

Харин Сүмбэр сум нь тус сумын ИТХ-ын тогтоолоор 2018 оны ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг батлуулсан боловч иргэд, байгууллагаас авсан саналын хуудас, урьдчилсан саналын жагсаалт, хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл, эрэмбэлсэн маягтуудыг аудитын явцад ирүүлээгүй болно.

Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1-д "Баг, хорооны Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна", 63.2-т "Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны ИНХ дээр гарсан саналыг ИНХ хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно" гэж заасан байна.

ОНХС-аар жил бүр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний саналыг иргэдээс авч саналыг нэгтгэн эрэмбэлж байгаа боловч санал ирээгүй ажлыг эрэмбэлсэн жагсаалтад нэмж тусгах зэргээр дээрх хуулийн заалтууд зөрчигдсөөр байна. Тухайлбал:

- Аймгийн ОНХС нь 2018 онд Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, Төмөр замын 1-р багт нийтийн бие засах газар байгуулах, зөөврийн хогийн сав байршуулах ажил, Хөдөөгийн багийн төвийн тохижилтын ажил /4-р баг/, Барилга, байгууламжуудыг паспортжуулах зөвлөх үйлчилгээний ажил, аймгийн ЗДТГ-ын хурлын заалны ширээ, сандал, тоног төхөөрөмж худалдан авах зэрэг нийт 119.9 сая төгрөгийн 5 ажлыг иргэдээс санал авч эрэмбэлээгүй байхад хэрэгжүүлсэн, Нийтийн тээврийн үйлчилгээг бодлогоор дэмжиж, дунд оврын автобус худалдан авах нэрээр санал авсан боловч батлагдсан төсвөөс аймгийн ЗДТГ-т суудлын автомашин 70.0 сая төгрөгөөр худалдан авсан байна.
- Шивээговь сумын ОНХС нь Шивээговь сумын Эрүүл мэндийн төвд эхо томографик 4D аппарат худалдан авах, Сургуулийн цахилгааны монтажийг хэсэгчлэн шинэчлэх, Соёлын төвийн дулаан,цэвэр бохир усны шугамыг сольж шинэчлэх, нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар хийх зэрэг нийт 80.6 сая төгрөгийг ажлыг иргэдээс санал авч эрэмбэлээгүй байхад хэрэгжүүлсэн байна.
- Баянтал сумын ОНХС нь 4 дүгээр сургуулийн 40 хүүхдийн ширээ сандал, Чийрэгжүүлэлтийн техник, тоног төхөөрөмж, 2-р багт мал угаалгын ванн хийх зэрэг нийт 21.6 сая төгрөгийн ажлыг иргэдээс санал авч эрэмбэлээгүй байхад хэрэгжүүлсэн байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6, 60.4, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан зааврын 4 дүгээр зүйлийн 4.2, 4.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд ОНХС-гийн хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж хэрэгжүүлж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

**2.2. ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримтлаагүй байна.**

**2.2.1 Зарим үнэлгээний хороо, ажлын хэсэг холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүйгээс жил бүр сонгон шалгаруулалттай холбоотой гомдол санал гарч байна.**

Аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын шинж чанартай нийт 20 төсөл, хөтөлбөрт 1,421.0 сая төгрөгийн төсөв батлагдсан байна.

Аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

| ОНХС-гийн нэр | Шинээр эхлэх хөрөнгө оруулалт | | Тоног төхөөрөмж | | Их засвар | | Хөтөлбөр төсөл, арга хэмжээ | | Нийт дүн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Төсөвт өртөг | Тоо | Төсөвт өртөг | Тоо | Төсөвт өртөг | Тоо | Төсөвт өртөг | Тоо | Төсөвт өртөг |
| **АОНХС** | 10 | 922.3 | 1 | 100.0 | 3 | 141.7 | | | 14 | 1,164.0 |
| **Сүмбэр сумын ОНХС** | 1 | 36.0 | 1 | 120.0 | | | | | 2 | 156.0 |
| **Шивээговь сумын ОНХС** | | | 1 | 50.0 | 2 | 35.0 | 1 | 16.0 | 4 | 101.0 |
| **Нийт дүн** | **11** | **958.3** | **3** | **270.0** | **5** | **176.7** | **1** | **16.0** | 20 | **1,421.0** |

Хүснэгтээс харахад: Шинээр эхлэх хөрөнгө оруулалтын ажил 67.5%, тоног төхөөрөмж худалдан авах ажил 19%, их засварын ажил 12.4%, хөтөлбөр, төсөл арга хэмжээ 1.1%-ийг тус тус эзэлж байна.

Аймгийн ОНХС-гийн 14 ажлаас 4 ажлыг нээлттэй тендер шалгаруулалт, 7 ажлыг харьцуулалт, 1 ажлыг ШХА-аар, 2 ажлыг зөвлөх үйлчилгээгээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар төлөвлөгөө батлагдсан боловч гүйцэтгэлээр 2 ажлыг нээлттэй тендер шалгаруулалт, 4 ажлыг харьцуулалт, 8 ажлыг шууд гэрээ байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Шивээговь сумын ОНХС нь хөрөнгө оруулалтын ажлын төсөвт өртгийг жижиглэн баталснаас 4 ажлын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан боловч харьцуулалт амжилтгүй болсноос 3 ажилд шууд гэрээг байгуулж, 1 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй байна.

Баянтал сумын ОНХС нь хөрөнгө оруулалтын ажлын төсөвт өртгийг жижиглэн баталснаас шууд худалдан авалтыг хийсэн байна.

Сүмбэр сумын ОНХС нь хөрөнгө оруулалтын ажлын төсөвт өртгийг жижиглэн баталснаас 1 ажлын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар, 1 ажлыг гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтаар сонгон шалгаруулсан байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газраас сонгон шалгаруулсан нийт 14 ажлаас 1 ажлын тендерт оролцогчоос Сангийн яаманд гомдол гаргаж хянуулсан байна. Үүнд:

1. Сүмбэр сумын 2 дугаар багт баригдах тохижилтын ажлын гүйцэтгэгчээр "Олон тоосго" ХХК шалгарсан боловч тендерт оролцогч "Гарден сити" ХХК-иас гомдол гаргасан байна. Гомдлыг хянан шийдвэрлэсэн тухай Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлого зохицуулалтын газрын 2018 оны 6-1/1369 дугаартай албан бичигт уг тендер шалгаруулалтын үнэлгээг хууль, журамд нийцүүлэн дахин хийхийг зөвлөснөөр дахин үнэлгээ хийж, шаардлага

хангасан тендер ирүүлээгүй гэсэн шалтгаанаар бүх тендерээс татгалсан байна.

2. Уг тендерийг дахин зарлаж оролцогчдоос шаардлага хангасан тендер ирүүлээгүй тул бүх тендерээс татгалзахад “Олон тоосго” ХХК дахин гомдол гаргасан бөгөөд гомдлыг хянан шийдвэрлэсэн тухай Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлого зохицуулалтын газрын 2018 оны 6-1/3674 дугаартай албан бичгээр уг тендер шалгаруулалтыг хуульд нийцсэн гэж үзсэн байна.

Дээрх гомдлыг шийдвэрлэсэн байдлыг харахад гомдол гаргагчийн хүсэлт нь үндэслэлтэй гэж гарсан бөгөөд үнэлгээний хороо, ажлын хэсэг холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүйгээс жил бүр сонгон шалгаруулалттай холбоотой гомдол санал гарч байна.

Тендер шалгаруулалтыг хууль журмын дагуу хийхгүй байгаа талаар жил бүр Сангийн яаманд гомдол санал гардаг зөрчил давтагдсаар байгаад анхаарч ажиллах шаардлагатай байна.

### 2.2.2. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн зарим ажлууд чанарын шаардлага хангаагүй, үр дүн, ашиглалт муутай байна.

2018 онд аймаг, сумдын ОНХС-гаар нийт 2,599.5 сая төгрөгийн 93 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсанаас 1,886.2 төгрөгийг зарцуулж, 713.3 сая төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

**Аймаг, сумдын ОНХС-гийн батлагдсан төсөв, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:**

/сая төгрөгөөр/

| ОНХС-гийн нэр | Батлагдсан төсөв | Гүйцэтгэл | Хэмнэлт |
|---|---|---|---|
| Аймгийн ОНХС | 2,011.2 | 1,374.3 | 636.9 |
| Сүмбэр сумын ОНХС | 335.5 | 303.0 | 32.5 |
| Шивээговь сумын ОНХС | 173.1 | 151.4 | 21.7 |
| Баянтал сумын ОНХС | 79.7 | 57.5 | 22.2 |
| Нийт дүн | 2,599.5 | 1,886.2 | 713.3 |

Хүнэгтээс харахад: 2018 онд хийгдэхээр төлөвлөсөн ажлын гүйцэтгэлээс аймгийн ОНХС-д 636.9 сая, Сүмбэр сумын ОНХС-д 32.5 сая, Шивээговь сумын ОНХС-д 21.7 сая, Баянтал сумын ОНХС-д 22.2 сая төгрөгийн тус тус үлдэгдэлтэй байна.

Аймаг, сумдын ОНХС-гийн дансны үлдэгдлийг дэлгэрэнгүй байдлаар ангилан хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

| Нэр | Аймгийн ОНХС | Сүмбэр сумын ОНХС | Шивээговь сумын ОНХС | Баянтал сумын ОНХС | ДҮН |
|---|---|---|---|---|---|
| Өмнөх оноос дамжсан ажлын санхүүжилт | 16.4 | 3.8 | | 19.1 | 39.3 |
| Шилжих хөрөнгө оруулалтанд илүү батлагдсан санхүүжилт | 25.1 | 20.4 | | | 45.5 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2018 оны дутуу гүйцэтгэсэн ажлын санхүүжилт** | 76.8 | | 0.1 | | **76.9** |
| **2018 онд хэрэгжээгүй ажлын санхүүжилт** | 455.2 | | 20.0 | | **475.2** |
| **Хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэмнэлт** | 32.2 | | 0.8 | 2.7 | **35.7** |
| **2018 оны ажлын гэрээний хэмнэлт** | 30.7 | 8.3 | 0.8 | 0.4 | **40.2** |
| **Өмнөх оны хөтөлбөрөөс буцаан тушаагдсан орлого** | 0.5 | | | | **0.5** |
| **Нийт дүн** | **636.9** | **32.5** | **21.7** | **22.2** | **713.3** |

Хүснэгтээс харахад: Он дамжсан ажлын санхүүжилт 5.5%, 2018 онд хэрэгжээгүй болон дутуу хийгдсэн ажлын санхүүжилт 77.4%, ажлын гэрээний болон хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэмнэлт 10.6%, шилжих хөрөнгө оруулалтанд илүү батлагдсан ажлын санхүүжилт болон буцаан тушаагдсан орлого 6.5%-ийг тус тус эзэлж байна.

Аймаг, сумдын 2018 оны ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтаар аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийг дурьдвал:

**<u>Аймгийн ОНХС-гийн зарцуулалт:</u>**

1. Нийтийн эзэмшлийн орон сууцнуудын гадна дулаалга, фасадны ажлыг 159.9 сая төгрөгийн ажлыг "Гурвандэлгэр" ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн боловч 1-р орцны код гаргасан будгийг зориулалтын өнгөөр будаагүй, өнгөлгөөний будгийг нимгэн будсанаас халтартсан.
2. Сүмбэр сумын 1-р багт нийтийн бие засах газар байгуулах, зөөврийн хогийн сав байршуулах 36.5 сая төгрөгийн ажлыг "Хөх үзүүр" ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн боловч нийтийн бие засах газрын агааржуулалт салсан, цонхнууд хагарсан.
3. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүлээн авах, амбулаторын их засварын 59.3 сая төгрөгийн ажлыг "Эс Жи Эм" ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн боловч шалны худаас нь эмнэлгийн стандартад нийцэхгүй амархан халтар болдог, хулдаасны амалгаа нь дутуу наагдснаас зай гарсан, өрөөнүүдийн хаалганы хуулга хуурсан, амалгаа нь эвдэрсэн.
4. Аймгийн нийтийн эзэмшлийн явган замын 19.2 сая төгрөгийн ажлыг "Их даян бүүвэй" ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн боловч зарим хэсэгт замын хашлага нь эвдэрч хавтангууд нь салсан.
5. Сүмбэр сумын 2 дугаар багт баригдсан тохижилтын 148.2 сая төгрөгийн ажлыг "ОСО констракшин" ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн боловч сууриулсан 2 хүүхдийн тоглоом, сандал, хогийн савнууд салж эвдэрсэн.
6. Аймгийн ЗДТГ-ын хурлын заалны ширээ сандал, тоног төхөөрөмж худалдан авахаар "Сүмбэр зууч" ХХК-тай 20.0 сая төгрөгийн гэрээг 2018.11.27-нд байгуулсан боловч гэрээний 2 дугаар зүйлийн 2.2-д "2 тал гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсны дараа худалдан авагч тал нь нийлүүлэгч талд урьдчилгаа төлбөр болон гэрээний үнийн дүнгийн 70 хувийн, төлбөрийг шилжүүлэх бөгөөд барааг хүлээн авч, акт үйлдсэний дараа үлдсэн 30 хувийн төлбөрийг нийлүүлэгч талд шилжүүлнэ" гэсэн заалтыг зөрчиж, гэрээний хуваарийг баримтлаагүй 2018.11.28-нд санхүүжилтийг 100 хувь шилжүүлсэн байна.

**<u>Сүмбэр сумын ОНХС-гийн зарцуулалт:</u>**

1. ЕБС-д ширээ, сандал нийлүүлэх 36.0 сая төгрөгийн ажлыг "Шивээгийн хөгжил" ЗБН-тэй гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн боловч ширээ сандал чанаргүй хийгдсэн, хүүхэд суухад тохиромжгүй, стандарт бус шаардлага хангахгүй байна.

**Шивээговь сумын ОНХС-гийн зарцуулалт:**

1. ЕБС-ын 3-р сургуулийн цахилгааны монтаж солих 19.8 сая төгрөгийн ажлыг "Энхжих формат" ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн боловч сургуулийн гал тогооны хэсэгт цахилгааны монтажны утас хамгаалалтгүй задгай, аюулгүйн байдал хангалтгүй хийгдсэн байна.

**Баянтал сумын ОНХС-гийн зарцуулалт:**

1. Баянтал сумын 4 дүгээр сургуульд 40 хос ширээ сандал нийлүүлэх 6.6 сая төгрөгийн гэрээг "Хөгжих лүн тал" ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн боловч бага ангийн сурагчдад зориулан нийлүүлсэн 10 ширхэг тус бүр нь 1.6 сая төгрөгийн үнэ бүхий ширээ, сандал стандартад нийцээгүй, хүүхдийн хөлд хөндлөвч төмөр нь тулсан, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг хангаагүй байна. Мөн ширээ, сандлын үнийг тус тусад нь үнэлж данс бүртгэлд тусгаагүйгээс эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд ямар үнээр данснаас хасах нь тодорхойгүй байна. Энэ нь захиалагч техникийн нөхцөлөө боловсруулахдаа үнийн дүнг салгаагүй, нэгдсэн нэг үнээр санал өгсөнөөс шалтгаалсан байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Иймд зарим чанаргүй хийгдсэн болон эвдэрсэн ажлуудыг гүйцэтгэгч байгууллагуудаар дахин засварлуулж хэвийн болгох, зориулалтын дагуу ашиглах боломж нөхцлөөр хангуулах арга хэмжээ авах, ажлын гүйцэтгэлийг бүрэн хангуулж ажиллах, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид гэрээний дагуу алданги тооцож ажиллах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

- Шивээговь сумын ОНХС-гаас Өвс тэжээлийн нэгдсэн фондыг нэмэгдүүлэх зорилгоор иргэн Б.Баяртогтохтой 714 боодол өвсийг 5.9 сая төгрөгөөр худалдан авахаар гэрээ байгуулсан боловч нийлүүлсэн өвс нь чанарын шаардлага хангаагүй хөгцөрсөн байснаас 4.7 сая төгрөгийг олгож, иргэн Т.Батнасантай 798 боодол өвсийг 5.9 сая төгрөгөөр худалдан авахаар гэрээ байгуулж 5.9 сая төгрөгийг олгож, өвсийг худалдан авсан боловч өвсний хадгалалт хураалт хангалтгүйгээс боодол нь задарсан, борог өвс ихтэй байснаас өвс нь зарагдаагүй, нийт 1,512 боодол өвс үхмэл хөрөнгө болсон, өмнөх өвсний үлдэгдэл дуусаагүй байхад дахин өвс худалдан авч төсвийн хөрөнгийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.
- Баянтал сумын Өргөх станцын зураг төсөв боловсруулах 10.0 сая төгрөгийн ажлыг "Кингсийн энд Инженер" ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгэсэн боловч гэрээний хугацаа 2018.01.15-нд дууссан байхад ажлыг одоог хүртэл хүлээн аваагүй, гэрээний дагуу алданги болон хариуцлага тооцоогүй, гүйцэтгэлээр санхүүжилт 7.0 сая төгрөгийг олгосон байна.

- Баянтал сумын 2-р багийн зураг төсөв боловсруулах 4.8 сая төгрөгийн ажлыг "Сталь-3003" ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн боловч гэрээний хугацаа 2018.01.10-нд дууссан байхад ажлыг хүлээн аваагүй, гэрээний дагуу алданги болон хариуцлага тооцоогүй гүйцэтгэлээр санхүүжилт 3.6 сая төгрөгийг олгосон байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Иймд худалдан авсан өвсөнд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж, шаардлага хангасан өвсийг зарах, мөн гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид гэрээний дагуу алданги тооцож, ажлыг хүлээн авах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

**2.2.3 ОНХС-гийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй, аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна.**

ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг санхүүгийн бүртгэл тайланд тусгахгүй орхигдуулдаг зөрчил өмнөх онуудтай харьцуулахад багассан боловч Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 8.6 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй зөрчлийг давтан гаргасан байна.

Аймгийн ИТХТ-ийн 2018.08.23-ны өдрийн 23, 2018.12.26-ны өдрийн 51 дүгээр тогтоолуудаар аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлыг орон нутгийн өмчид бүртгэх зөвшөөрөл олгосон байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлыг данс бүртгэлд тусгуулах жагсаалт гаргахдаа зарим ажлыг давхардуулж тусгасан бол зарим ажлыг орхигдуулсан байна. Үүнд:

1. Нийтийн эзэмшлийн авто зам дагуух гэрэлтүүлгийн толгойг шинэчлэх ажлыг 2018.08.23-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор "Тохижилт Сүмбэр" ОНӨААҮГ-т, 2018.12.26-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор АЗДТГ-т бүртгүүлэхээр,
2. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүлээн авах, амбулаторийн их засварын ажлыг 2018.08.23-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор "Аймгийн Нэгдсэн эмнэлэгт", 2018.12.26-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор АЗДТГ-т бүртгүүлэхээр тус тус давхардуулж тогтоол гаргасан байна.
3. Аймгийн ОНХС-гаар хийгдсэн Хаус хорооллын ерөнхий төлөвлөгөө, нэг маягийн зураг 21.0 сая төгрөг, Найрамдал хотхоны нийтийн эзэмшлийн орон сууцнуудад барилгын дүгнэлт гаргуулах ажлын 5.0 сая төгрөг, Барилга, байгууламжуудыг паспортжуулах зөвлөх үйлчилгээний ажил 10.0 сая нийт 36.0 сая төгрөгийн ажлыг хүлээн авсан боловч данс бүртгэлд тусгах талаар тогтоолд тусгаагүй байна.

Мөн дээрх тогтоолын хэрэгжилт хангалтгүйгээс зарим ажлыг данс бүртгэлд тусгаагүй зөрчил илэрлээ. Үүнд: Аймгийн ОНХС-гаас хийгдсэн Нийтийн эзэмшлийн орон сууцнуудын гадна дулаалга, фасадны ажил зэрэг нийт 159.9 сая төгрөгийн ажлыг данс бүртгэлд тусгаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, Сангийн сайдын 43 дугаар тушаалаар баталсан ОНХС-гийн зааврын 8 дугаар зүйлийн 8.6, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журмын 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгээгүй 159.9 сая төгрөгийн зөрчилтэй холбогдуулан зөрчлийг арилгуулах албан шаардлага өгч, ИТХТ-ийн тогтоолыг үнэн зөв гаргах, данс бүртгэлд тусгах, хөрөнгө бүртгэх шийдвэрийг давхардуулахгүй болон орхигдуулахгүй байх, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

ОНХС-гийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжилтийн байдалд хууль журмын дагуу хянаж тайлагнасан үү

# Бүлэг 3

**ОНХС-гийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт хийгдээгүй байна.**

## 3.1 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллаагүй байна.

### 3.1.1 Аймаг, сумдын ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо, иргэд, Иргэний нийгмийн байгууллагуудаас тавих хяналт хангалтгүй байна.

Аудитын явцад аймгийн болон сумдын ИТХ-ын дэргэдэх хяналтын хороодын хяналт тавьсан ажлын тайланг албан бичгээр авч танилцав.

Тайлант онд хяналтын хороод аймгийн ОНХС-гийн 6 ажил Баянтал сумын ОНХС-гийн 5 ажил, Шивээговь сумын ОНХС-гийн 10 ажил, Сүмбэр сум ОНХС-гийн 13 ажил, нийт 34 ажилд хяналт тавьж ажилласан гэх боловч хяналтын хороод хяналт шалгалт хийхдээ тухайн ажлуудтай танилцах төдий хяналт шалгалт хийж, зөрчил дутагдал илрүүлээгүй, үүрэг даалгавар өгөөгүй бөгөөд зөвхөн мэдээлэл, танилцуулгын хэлбэртэй тайлан бичсэн байна.

### 3.1.2 Аймаг, сумын захиргааны байгууллага ОНХС-гийн хэрэгжилт, үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээг хийгээгүй байна.

2018 оны аймаг, сумдын ОНХС-гийн хэрэгжилтэнд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Харин аймгийн ЗДТГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 2016-2017 оны сумдын ОНХС-гийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэх, мэдлэг олгох сургалтыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн, Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн нар хамтран зохион байгуулж, сумдын Засаг дарга нарт худалдан авах ажиллагааны талаар 23 чиглэл бүхий зөвлөмж хүргүүлсэн байна.

Мөн аймгийн Засаг даргын А/112 дугаар захирамжаар аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2017 оны гүйцэтгэлд аймгийн Төрийн аудитын газраас хийсэн Нийцлийн аудитын зөвлөмжийн хэрэгжилт, 2018 оны Орон нутгийн хөгжлийн сангийн төсөл хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэлд хяналт-шинжилгээ дотоод аудит хийх ажлын хэсгийг 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хийж дуусган үр дүнг танилцуулахыг ажлын хэсгийн дарга Х.Буянбаярт үүрэг болгосон бөгөөд аудитын явцад ажлын хэсгийн дүн гараагүй, хугацаа нь болоогүй байна.

**3.2.1 Аймаг, сумд ОНХС-гийн хэрэгжилтийн тайланг хүргүүлж ажилласан байна.**

Аймаг, сумын ОНХС болон хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтнүүд ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэлийн тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, "Тогтвортой амжиргаа-3" төсөлд Сангийн сайдын 228 дугаар журмын дагуу тогтоосон хугацаанд тайлагнан ажилласан байна.

**3.2.2 Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагын хэрэгжилт 69.4 хувьтай байна.**

2017 оны ОНХС-д хийгдсэн Нийцлийн аудитаар нийт 1,869.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 1,573.5 сая төгрөгийн 10 албан шаардлага, 296.0 сая төгрөгийн 25 зөвлөмж өгөгдсөнөөс зөвлөмж болон 757.3 сая төгрөгийн 4 албан шаардлагын хэрэгжих хугацаа болоогүй, 816.2 сая төгрөгийн 6 албан шаардлагыг хэрэгжүүлэхээс 566.6 сая төгрөгийн 4 албан шаардлагыг хэрэгжүүлж, 249.6 сая төгрөгийн 2 албан шаардлагыг хугацаанд нь хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Баянтал сумын ОНХС-аар хэрэгжсэн 212.6 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгах, Сүмбэр сумын ОНХС-ийн данс бүртгэлд он удаан жил хуримтлагдан бүтгэгдсэн 37.0 сая төгрөгийн авлага, өглөгийг барагдуулах 2 албан шаардлага хэрэгжээгүй байна.

Аудитаар нийт 603.7 сая төгрөгийн зөрчил дутагдал илрүүлснээс 230.9 сая төгрөгийн албан шаардлага, 372.8 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгуулах зөвлөмж өглөө.

## ДҮГНЭЛТ

**Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.**

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1. ОНХНС-гаас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгосон байна.
2. Аймгийн ОНХС-гийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна.
3. ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох хууль тогтоомж, зааврыг баримтлаагүй, ОНХС-гийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлдэг зөрчил давтагдан гарсаар байна.
4. Зарим үнэлгээний хороо, ажлын хэсэг холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүйгээс жил бүр сонгон шалгаруулалттай холбоотой гомдол, санал гарсаар байна.
5. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн зарим ажлууд чанарын шаардлага хангаагүй, үр дүн, ашиглалт муутай,, гэрээний үүргийг зөрчиж санхүүжилтийг хуваарийн дагуу олгоогүй байна.
6. ОНХС-гийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй, аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна.
7. ОНХС-гийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжилтийн байдалд хяналт, шалгалт хийгдээгүй байна.
8. Аймаг, сумд ОНХС-гийн хэрэгжилтийн тайланг хүргүүлж ажилласан байна.
9. Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагын хэрэгжилт 69.4 хувьтай байна.

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

**Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргад:**

1. ОНХС-гийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, ОНХС-гийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байх
2. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн зарим ажлууд чанарын шаардлага хангаагүй, үр дүн, ашиглалт муутай байгаад анхаарч ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх
3. ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох хууль тогтоомж, зааврыг баримтлаагүй, ОНХС-гийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлдэг зөрчил давтагдан гарсаар байгаад анхаарч ажиллах
4. ОНХС-гийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг холбогдох байгууллагын данс бүртгэлд бүрэн тусгуулах, хөрөнгийг орхигдуулахгүй байх, хянах
5. Ажлын санхүүжилтийг гэрээнд заасан хуваарийн дагуу олгож байх
6. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн гэрээний хугацаанд хүлээн аваагүй ажилд гэрээний дагуу алданги тооцох, гэрээг дүгнэж ажиллах
7. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх

**Аймгийн орон нутгийн өмчийн газрын даргад:**

1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа зарим үнэлгээний хороо, ажлын хэсэг холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүйгээс жил бүр сонгон шалгаруулалттай холбоотой гомдол, санал гарсаар байгаад анхаарч ажиллах, үнэлгээний хорооны гишүүдэд зөвлөмж чиглэл өгч ажиллах
2. ОНХС-гийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй, аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилт хангалтгүй, зарим ажлуудыг давхардуулан болон орхигдуулан тогтоол гаргуулж байгаад анхаарч ажиллах, тогтоолын хавсралтаар батлагдаж буй жагсаалтыг сайтар хянах

**Сумдын Засаг дарга нарт**

1. ОНХС-гийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, ОНХС-гийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байх
2. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн зарим ажлууд чанарын шаардлага хангаагүй, үр дүн, ашиглалт муутай байгаад анхаарч ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх
3. ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох хууль тогтоомж, зааврыг баримтлаагүй, ОНХС-гийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлдэг зөрчил давтагдан гарсаар байгаад анхаарч ажиллах
4. ОНХС-гийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг холбогдох байгууллагын данс бүртгэлд бүрэн тусгуулах, хөрөнгийг орхигдуулахгүй байх, хянах

5. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн гэрээний хугацаанд хүлээн аваагүй ажилд гэрээний дагуу алданги тооцох, гэрээг дүгнэж ажиллах
6. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих хөтөлбөр төсөл арга хэмжээнд явцын хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх
7. ОНХС-гаас өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах

# ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Аймгийн ХОХБТХ болон сумын Засаг дарга нараас ирүүлсэн санал:

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Найрамдал хотхон, Утас/Факс: (976) 7054 3118,
И-мэйл: zdtg.gsa@gmail.com, Вэбсайт: www.govisumber.gov.mn

2019.04.09 № 01/327

танай ____________-ны №____________-т

**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын 2018 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайланд тусгах саналгүй болно.

Хүндэтгэсэн;

ДАРГА Д.СОДНОМ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГА**

42030 Говьсүмбэр аймаг, Шивээговь сум,
Утас: 7054 6426, И-мэйл: shiweegovi.zdtg@gmail.com

2019.04.09 № 1/288

танай ____________-ны №____________-т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

И.Батцайхан
Санхүүгийн тайлан
түгээх
5/09

Тайлбар хүргүүлэх тухай

Шивээговь сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитын нэгтгэлтэй танилцаж дараах тайлбарыг гаргаж байна. Үүнд:

Зөвлөмж: Эрүүл мэндийн төвд эхо томографик 4D аппарат худалдан авах, Сургуулийн цахилгааны монтажийг хэсэгчлэн шинэчлэх, Соёлын төвийн дулаан, цэвэр, бохир усны шугамыг сольж шинэчлэх, Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар хийх зэрэг ажлуудыг иргэдээс санал авч эрэмбэлээгүй байхад хэрэгжүүлсэн байна.

Тайлбар: Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр дараа онд хийгдэх ажлын саналыг иргэдээс авахдаа саналын хуудсаар дамжуулан авдаг хэдий ч иргэдээс ирүүлсэн санал бүрийг багийн Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэх үеэр иргэдээс шинээр гарсан саналыг мөн эрэмбэлж ажилласан.

1 дүгээр багийн иргэдийн нэгдсэн саналын 6, 11, 19 дүгээр хэсэг, 2 дугаар багийн иргэдийн нэгдсэн саналын 7, 14 дүгээр хэсгүүдэд дээрх ажлуудад өгсөн иргэдийн саналыг тусгасан байгаа бөгөөд сумын Засаг даргын захирамжаар томилогдсон "Төсөл, арга хэмжээг төлөвлөхөд арга зүйн зөвлөгөө өгөх" ажлын хэсгийн хурлын шийдвэрээр сумын 2018 онд хэрэгжүүлэх ажлын нэгдсэн жагсаалтын 6, 13, 21, 47 дахь хэсгүүдэд дээрх ажлуудыг эрэмбэлсэн байна.

ЗАСАГ ДАРГА С.ЯГААНЦЭЦЭГ

E:\2019 oni barimt
4251900072

# ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ХИЙСЭН ТАЙЛБАР

Холбогдох байгууллагуудаас ирүүлсэн тайлангийн төсөлд өгсөн саналтай танилцаад хууль эрхийн үндэслэлтэй тайлбар ирүүлээгүй тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

## Говьсүмбэр аймгийн Баянтал сумын ОНХС-ийн 2018 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн нэгтгэл

2019.04.05

/ мян.төг/

| № | Зөрчлийн утга | Зөрчлийн дүн /мян.төг/ Зориулалт Тоо | Зориулалт Дүн | Иргэдийн Тоо | Иргэдийн Дүн | Дутуу буюу Тоо | Дутуу буюу Дүн | Бүртгэлд Тоо | Бүртгэлд Дүн | Бусад Тоо | Бусад Дүн | Нийт дүн Нийт тоо | Нийт дүн Нийт дүн | Шийдвэрлэсэн байдал Хариуцлага тооцох | Хуулийн байгууллагад | Албан шаардлага | Акт | Зөвлөмж | Нийт зөрчлийн дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 4 дүгээр сургуулийн 40 хүүхдийн ширээ сандал,Чийрэгжүүлэлтийн техник, тоног төхөөрөмж, 2-р багт мал угаалгын ванн хийх зэрэг ажлуудыг иргэдээс санал авч эрэмбэлээгүй байхад хэрэгжүүлсэн байна. | | | 3 | 21,600.0 | | | | | | | | | | | | | 21,600.0 | 21,600.0 |
| 2 | 4-р сургуульд 40 сандал ширээ нийлүүлэх ажлын гэрээг "Хөгжих Лүн тал" ХХК-аар гүйцэтгүүлсэн боловч бага ангийн сурагчдад зориулан нийлүүлсэн ширээ сандал чанаргүй хийгдсэн, стандартад нийцэхгүй байна. | | | | | 1 | 1,650.0 | | | | | 1 | 1,650.0 | | | 1,650.0 | | | 1,650.0 |
| 3 | 1. Баянтал сумын Өргөх станцын зураг төсөв боловсруулах 10,000.0 сая төгрөгийн ажлыг "Кингсийн энд Инженер" ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгэсэн боловч гэрээний хугацаа 2018.01.15-нд дууссан байхад ажлыг хүлээн аваагүй гүйцэтгэлээр санхүүжилт 7.0 сая төгрөгийг олгосон гэрээний үүргээ биелүүлээгүй.<br>2. Баянтал сумын 2-р багийн зураг төсөв боловсруулах 4.8 сая төгрөгийн ажлыг "Сталь-3003" ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн боловч боловч гэрээний хугацаа 2018.01.10-нд дууссан байхад ажлыг хүлээн аваагүй, гүйцэтгэлээр санхүүжилт 3.6 сая төгрөгийг олгосон гэрээний үүргээ биелүүлээгүй. | | | | | 2 | 14,800.0 | | | | | 2 | 14,800.0 | | | 14,800.0 | | | 14,800.0 |
| | **Нийт зөрчлийн дүн** | - | - | **3** | **21,600.0** | **3** | **16,450.0** | - | - | - | - | **3** | **16,450.0** | - | - | **16,450.0** | - | **21,600.0** | **38,050.0** |

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэл хөтөлсөн аудитор: М.Ундармаа

Зөвшөөрсөн: Баянтал сумын засаг дарга Д.Мөнх-Эрдэнэ

Зөвшөөрсөн: Мэргэжилтэн Д.Бямбадулам

Хянасан: Дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2019 оны 04 сарын 08 өдөр Дугаар 03/31 Чойр

Зөрчил арилгуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторт Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас 2019 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөө, Нийцлийн аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд "Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны хөрөнгийн зарцуулалт"-д хийсэн Нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Баянтал сумын 4 дүгээр сургуульд 40 сандал ширээ нийлүүлэх ажлын гэрээг "Хөгжих Лүн тал" ХХК-аар гүйцэтгүүлсэн боловч бага ангийн сурагчдад зориулан нийлүүлсэн 1,650.0 мянган төгрөгийн 10 ширхэг ширээ, сандал чанаргүй хийгдсэн, стандартад нийцээгүй байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтуудыг зөрчсөн байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1 дэх хэсгийг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Чанаргүй хийгдсэн, стандартад нийцээгүй 1,650,000.00 төгрөгийн 10 ширхэг бага ангийн ширээ, сандлыг дахин засварлуулж, зөрчлийг арилгах
2. Албан шаардлагын биелэлтийг 2019 оны 08 дугаар сарын 25-ны дотор гаргаж, Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянтал сумын Засаг дарга Д.Мөнх-Эрдэнэ, мэргэжилтэн Д.Бямбадулам нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

**ӨГСӨН**[1]**:**

АУДИТОР: М.УНДАРМАА

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.САРАНТУЯА

**ЗӨВШӨӨРСӨН:**

ЗАСАГ ДАРГА: Д.МӨНХ-ЭРДЭНЭ

МЭРГЭЖИЛТЭН: Д.БЯМБАДУЛАМ

[1] *Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2019 оны 04 сарын 08 өдөр Дугаар 04/32 Чойр

Зөрчил арилгуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторт Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас 2019 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөө, Нийцлийн аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд "Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны хөрөнгийн зарцуулалт"-д хийсэн Нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Чийрэгжүүлэх тоног төхөөрөмж нийлүүлэх 5,000.0 мянган төгрөгийн гэрээг "Их зэст хөгжил" ХХК-тай байгуулсан боловч техникийн тодорхойлолтыг гэрээнд тусгаагүй, ажлыг хүлээн аваагүй байна.
- Бялдаржуулах тоног төхөөрөмж нийлүүлэх 7,630.0 мянган төгрөгийн гэрээг "Мөнх хүлэг хурд" ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн боловч ажлыг хүлээн аваагүй, байрны засвар чанаргүй хийгдсэн байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1 дэх хэсгийг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Чанаргүй хийгдсэн засварын ажлыг дахин хийлгүүлэх, 12,630,000.00 төгрөгийн гэрээг дүгнэж ажлыг хүлээн авах, гэрээний үүргийг биелүүлж зөрчлийг арилгах
2. Албан шаардлагын биелэлтийг 2019 оны 06 дугаар сарын 25-ны дотор гаргаж, Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянтал сумын Засаг дарга Д.Мөнх-Эрдэнэ, мэргэжилтэн Д.Бямбадулам нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

| **ӨГСӨН1:** | | **ЗӨВШӨӨРСӨН:** | |
|---|---|---|---|
| АУДИТОР: | М.УНДАРМАА | ЗАСАГ ДАРГА: | Д.МӨНХ-ЭРДЭНЭ |
| ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Б.САРАНТУЯА | МЭРГЭЖИЛТЭН: | Д.БЯМБАДУЛАМ |

[1] *Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*

**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс:976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn


2019.04.10 № 146

танай ____________-ны № ____________-т

СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ

Зөвлөмж хүргүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ болон Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас 2019 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөө, Нийцлийн аудитын газрын нэгдсэн удирдамж, төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд “ОНХС-гийн 2018 оны хөрөнгийн зарцуулалт”-д хийгдсэн Нийцлийн аудитын тайлангийн дүнг үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. ОНХС-гийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, ОНХС-гийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байх
2. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн зарим ажлууд чанарын шаардлага хангаагүй, үр дүн, ашиглалт муутай байгаад анхаарч ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх
3. ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох хууль тогтоомж, зааврыг баримтлаагүй, ОНХС-гийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлдэг зөрчил давтагдан гарсаар байгаад анхаарч ажиллах
4. ОНХС-гийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг холбогдох байгууллагын данс бүртгэлд бүрэн тусгуулах, хөрөнгийг орхигдуулахгүй байх, хянах
5. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн гэрээний хугацаанд хүлээн аваагүй ажилд гэрээний дагуу алданги тооцох, гэрээг дүгнэж ажиллах
6. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих хөтөлбөр төсөл арга хэмжээнд явцын хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх
7. ОНХС-гаас өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах

Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, зөвлөмжийн биелэлтийг 2019 оны 09 дүгээр сарын 15-ны дотор гаргаж ирүүлнэ үү.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА